



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 06 сарын \_\_\_ өдөр

Дугаар 336

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах ┐  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээх зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.4, 6.4.4, 6.4.6, 6.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Архангай аймаг дахь Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2,502,100.00 (хоёр сая таван зуун хоёр мянга нэг зуун) төгрөгийн балансын үнэ, 166,857.44 (нэг зуун жаран зургаан мянга найман зуун тавин долоон төгрөг дөчин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан барилгыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Улсын ерөнхий прокурорын газрын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Архангай аймаг дахь Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Б.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Барилга байгууламжийг буулгах, ашиглаж болох материалыг үнэ тогтоон орлогод авах эсхүл хоёрдогч түүхий эд болгон ашиглах, хог хаягдлыг цэвэрлэх, газрыг нөхөн сэргээх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

137005500  
17-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 06 дугаар сарын 22 өдрийн  
236 дугаар тогтоолын хавсралт



Архангай аймгийн Прокурорын газрын хөрөнгөд бүртгэлтэй  
акталж дансаас хасах хөрөнгийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр байршил	Ашиглалтад орсон огноо	Тоо ширхэг	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Автомашинны гараж (Архангай аймаг Эрдэнэбулган сум)	1992	1	2,502,100.00	166,857.44	2,335,242.56
	Нийт дүн		1	2,502,100.00 (хоёр сая таван зуун хоёр мянга нэг зуу)	166,857.44 (нэг зуун жаран зургаан мянга найман зуун тавин долоон төгрөг дөчин дөрвөн мөнгө)	2,335,242.56 (хоёр сая гурван зуун гучин таван мянга хоёр зуун дөчин хоёр төгрөг тавин зургаан мөнгө)